

ЭМ ЗҮЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН АЧААЛАЛ ТООЦОХ СУДАЛГАА

Анударь.О¹, Уламбаяр.Л.

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

STUDY OF SPECIALIST WORKLOAD

Anudari O, Ulambayar L.

Mongolian University of Pharmaceutical Sciences

Anunaa.goo@gmail.com

ABSTRACT

Introduction: High workloads among medical professionals can have adverse effects on their performance, the quality and safety of patient care. However, Zoljargal's 2021 study indicates that existing legal documents frequently offer additional compensation based on factors like skill level and exposure to hazardous conditions, all while lacking a comprehensive assessment of work performance, actual working hours, knowledge, experience, and workload. This research gap underscores the importance of investigating the workload of medical pharmacy professionals.

Methods: The research utilized chronometric methods and content analysis.

Result: In the study, a total of 42 professionals participated. The work efficiency of professionals in the departments of research institutions of levels II and III was studied using the method of chronometry, and they worked for an average of 44.9±3.236 hours over 5 working days, with 12.5-20.4 hours (31.25%-51%) spent on core tasks and 8.2-14.2 hours (20.5%-35.5%) on documentation tasks. Additionally, the workload of professionals in research institutions is highest on Tuesdays and Fridays, with 9.1 hours and 8.7 hours of work, respectively. The employees worked for an average of 35.15 hours and a maximum of 51.62 hours per week, with an average of 45.015±3.236 hours.

Conclusion:

Key words: Hospital pharmacy, workload, Chronometric method

Үндэслэл:

Эм хангамжийн байгууллага нь үйл ажиллагаандаа эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг тасралтгүй жигд хүртээмжтэй хангах зарчмыг баримтална. 2022 онд Монгол Улсын хэмжээнд нийт 3130 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас эмийн сан нь 2595 (84.7%), ханган нийлүүлэх байгууллага нь 495 (13.9%), эмийн үйлдвэр нь 40 (1.4%) -ийг эзэлж байна¹.

Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал их байх нь ажлын гүйцэтгэл болон тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөлөөлдөг. Одоогоор мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримтад эмнэлгийн мэргэжилтэнд ур чадварын зэргийн нэмэгдэл, хүнд хортой нөхцөлд нэмэгдэл цалин олгогддог боловч ажлын гүйцэтгэлийн үр дүн, ажилласан бодит хугацаа, мэдлэг туршлага, ажлын ачаалал зэргийг бүрэн үнэлэхгүй байна гэж (Золжаргал

П.) 2021 судалгаагаар тогтоосон байна².

Иймээс эмнэлгийн эмийн сангийн мэргэжлийн ажилчдын ажлын ачааллыг тооцсон судалгаа хомс байгаа нь энэхүү сэдвийг сонгох нь үндэслэл болж байна.

Зорилго, зорилт:

Эмнэлгийн дэргэдэх Эм зүйн албаны мэргэжилтний ажлын ачааллыг тооцоход судалгааны ажлын зорилго оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Эмнэлзүйн эм зүйчийн ажлын ачаалал тооцох
2. Эмнэлгийн Эм зүйн албаны даргын ажлын ачаалал тооцох
3. Нөөцийн тасгийн эм зүйчийн ажлын ачаалал тооцох

Арга, аргачлал

Судалгааг хронометрийн аргаар ажлын байрны зураг авалт (6 бүлэг бүхий асуумж

судалгааны карт) хийж, контент анализ зэрэг аргыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Хронометрийн арга

“Хронометр” гэдэг үг нь өөрөө “цаг хугацаа” (chronos) ба “хэмжих” (метр) гэсэн хоёр Грек үгнээс гаралтай.

Хронометрийн арга нь байнга дахин давтагдах ажил, ажилбарын цаг зарцуулалтыг судалдаг. Энэхүү аргыг эрүүл мэндийн салбарт хоёр үндсэн зорилгоор хэрэглэнэ³. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын мэргэжилтнүүдийн ажлын цаг ашиглалт, ажлын хуваарилалт, хөдөлмөрийн сахилга бат, цаг ашиглалт, хөдөлмөр зохион байгуулалтад үнэлэлт, дүгнэлт хийх зорилгоор хийдэг.
2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын ачааллын норм тогтооход хэрэглэнэ.

Эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын хуваарь, ажлын ачааллын норм тогтоох зорилгоор хийх хронометрийн ажиглалтыг урьдчилан сонгогдсон эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажиглалтын зорилго, ач холбогдлыг танилцуулж, зохион байгуулалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажиглалтад хамрагдах ажилтны тоо, ажиллах дэг журам, ажлын хуваарь, дэс дараалал, асуумж судалгааг урьдчилан боловсруулан бэлтгэж явуулна.

Хронометрийн ажиглалтыг ажлын 1-5 өдрөөр, шаардлагатай бол ажлын өдрийг нэмэгдүүлэн нэг төрлийн ажилбарыг 2-3 ажилтан дээр хийнэ. Хөдөлмөр зарцуулалтыг тооцоход эмнэлгийн эм зүйн албаны

мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт болон салбарын ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг ашиглана.

Контент-анализ

1. Харилцааны агуулгыг тоо, чанар, систем, объектив талаас нь үнэлж дүгнэх судалгааны техник.
2. Нийгмийн бодит байдлын шинж чанар, нөхцөл байдлын тухай эх бичвэрийн агуулгыг задлан шинжлэх замаар дүгнэлт гаргах арга юм.

Мөн судлаачид контент анализыг “багц үйлдлүүдийн тусламжтайгаар эх бичвэрээс үндэслэл бүхий дүгнэлтүүд гаргахад чиглэсэн судалгааны арга”, “баримтаас түүний агуулгад хамаарах үндэслэл бүхий, давтагдах дүгнэлтүүдийг гаргахад чиглэсэн судалгааны арга техник юм.

Хамрах хүрээ

Улаанбаатар хотын нийт 9 дүүргийн 4 дүүргийн D01, D04, D02, D03 (II шатлал) болон K03, K02 (III шатлал) код бүхий Эм зүйн албаны нийт 42 мэргэжилтэн хамрагдсан болно.

Үр дүн:

Эмнэлзүйн эм зүйч, эм зүйчийн ажлын ачаалал тооцсон дүн.

Судалгаанд хамрагдсан II шатлалын эмнэлгийн нийт эмнэлзүйн эм зүйч, эм зүйч тус бүрийн ажлын 5 өдрийн ажлын ачаалал болон тэдгээрийн дунджийг тооцсон дүнг дараах зургаар харуулав. (Зураг 1.)




Figure 1. Second tier hospital pharmacists average working hours

Зураг 1-с харахад D04-ийн эмнэлгийн Эм зүйч ажлын 5 өдрийн дундаж 45.1 цаг, D02-ийн эм зүйч нарын дундаж 46.0 цаг, D03-ийн эм зүйч нарын дундаж 46.6 цаг, D01-ийн эм зүйч нарын дундаж 45.7 цаг тус тус ажилласан байна. II шатлалын эмнэлгүүдийн эм зүйчийн

ажлын 5 өдрийн дундаж 46.1 цаг байна. (Зураг 1.)

II шатлалын эмнэлгүүдийн эм зүйчийн ажилласан цагийн задаргааг дараах зургаар харуулав. (Зураг 2.)




Figure 2. Second tier hospital pharmacists, clinical pharmacists working hours in detail

II шатлалын эмнэлгүүд буюу нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдийн Эм зүйн албаны эмнэлзүйн эм зүйч, эм зүйч нарын ажлын 5 өдрийн нийт ажилласан цагийн задаргаанаас харахад ажлын цагийн 19.9-26.6 (50%-66.5%) цагийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж байгаа бол 7.4-14.2 (18.5%-35.5%) цагийг бичиг баримтын ажилд, 5.2-7.9 (13%-20%) цагийг хувийн хэрэгцээнд тус тус зарцуулсан байна. Үүнээс харахад эмнэлзүйн эм зүйч нарын ажлын байрны гол үйл ажиллагаа болох эмэн эмчилгээтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох нь маш бага байна. Үндсэн

үйл ажиллагааны цагийн 5%-56%-г тасагт эм, бараа материал олгох, 3%-40%-г өвчний түүхэнд хяналт хийх, 38%-95%-г тасагт тоолдог эм, тариаг нэгж тунгаар олгоход зарцуулж байна. (Зураг 2.)

Эмнэлгийн Эм зүйн албаны даргын ажлын ачаалал тооцсон дүн

II шатлалын эмнэлгүүд буюу нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажлын 5 өдрийн дундаж цагийг тооцов. (Зураг 3.)




Figure 3. Average working hours of the head of the pharmaceutical department of second tier hospitals

Дээрх зургаас харахад II шатлалын эмнэлгүүд болох D04-ийн Эм зүйн албаны дарга 35.2 цаг, D02-ийн Эм зүйн албаны дарга 48.0 цаг, D03-ийн Эм зүйн албаны дарга 45.9 цаг, D01-ийн Эм зүйн албаны дарга 43.5 цаг ба эдгээрийн дундаж нь 43.1 цаг байна. Үүнийг

дээрх II шатлалын эмнэлгүүдийн эм зүйч нарын ажлын ачаалалтай харьцуулахад 3 цагаар бага байна. (Зураг 3.)

II шатлалын эмнэлгүүд Эм зүйн албаны дарга нарын ажилласан дундаж цагийн задаргааг тооцсон зургийг доор харуулав. (Зураг 4.)




Figure 4. Detailed working hours of the head of the pharmaceutical department in second tier hospitals

II шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажлын 5 өдрийн нийт ажилласан цагийн задаргаанаас харахад ажлын цагийн 0.0-8.6 (0%-21.5%) цагийг үндсэн үйл ажиллагаанд, 13.6-21.4 (34%-53.5%) цагийг бичиг баримтын ажилд, 4.7-6.2 (11.8%-15.5%) цагийг хувийн хэрэгцээнд зарцуулж байна. Харин албан ярианд ажлын 3.4-10 (8.5%-25%) цагийг зарцуулсан байна. Бичиг баримтын

цагийн 5%-г гэрээ шалгах, 8%-65%-г бичиг баримт цэгцлэх, албан бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэх, 22%-г захиалгын бараа орлогодож авах, 26%-75%-г тайлан гаргах, 66%-г зарлага шивэхэд зарцуулж байна. (Зураг 4.)

III шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажлын 5 өдрийн ажилласан дундаж цагийг тооцов. (Зураг 5.)




Figure 5. Average working hours of the head of the pharmaceutical department of tertiary hospitals

Дээрх зургаас харахад III шатлалын эмнэлгүүд болох K03-ийн Эм зүйн албаны дарга 47.3 цаг, K02-ийн Эм зүйн албаны дарга 44.4 цаг байна. Үүнийг дээрх II шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажлын ачаалалтай харьцуулахад 2.7 цагаар их

байна. III шатлалын эмнэлгүүдийн ЭЗ, ЭЭЗ-н ажилласан цагийн нийлбэртэй харьцуулахад 0.5 цагаар бага байна. (Зураг 5.)

III шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажилласан дундаж цагийн задаргааг тооцов. (Зураг 6.)




Figure 6. Working hours of tertiary hospital head of the pharmaceutical departments in detail

III шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны дарга нарын ажлын 5 өдрийн нийт ажилласан цагийн задаргаанаас харахад ажлын цагийн 7.3-11.2 (18.3%-28%) цагийг албан ярианд, 22.1-31.2 (55.3% -78%) цагийг бичиг баримтын ажилд, 2.5-3.4 (6.3%-8.5%) цагийг хувийн хэрэгцээнд тус тус зарцуулж байна. Бичиг баримтын цагийн 19%-26%-г гэрээ шалгах, 38%-81%-г бичиг баримт цэгцлэх, албан бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэх, 37%-г тайлан

гаргахад зарцуулж байна. (Зураг 6.)

Нөөцийн тасгийн эм зүйчийн ажлын ачаалал тооцсон дүн

II шатлалын эмнэлгүүд буюу нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдийн Эм зүйн албаны нөөцийн тасгийн эм зүйч нарын ажлын 5 өдрийн ажилласан дундаж цагийг тооцов. (Зураг 7.)




Figure 7. Average working hours of supply chain manager in second tier hospitals

Дээрх зургаас харахад II шатлалын эмнэлгүүд болох D02-ийн нөөцийн тасгийн эм зүйч 45.0 цаг, D04-ийн нөөцийн тасгийн эм зүйч 42.8 цаг, D01-ийн нөөцийн тасгийн эм зүйч 41.1 цаг ба эдгээрийн дундаж нь 43.0 цаг байна. Үүнийг дээрх II шатлалын эмнэлгүүдийн эм зүйч нарын ажлын ачаалалтай харьцуулахад

3.1 цагаар бага, Эм зүйн албаны дарга нартай харьцуулахад 0.1 цагаар бага тус тус байна. (Зураг 7.)

II шатлалын эмнэлгүүд Эм зүйн албаны нөөцийн тасгийн эм зүйч нарын ажилласан дундаж цагийн задаргааг тооцоход: (Зураг 8.)




Figure 8. Working hour details of second tier hospitals supply chain manager

II шатлалын эмнэлгүүдийн Эм зүйн албаны нөөцийн эм зүйч нарын ажлын 5 өдрийн нийт ажилласан цагийн задаргаанаас харахад ажлын цагийн 19.4-27.6 (48.5%-69%) цагийг үндсэн үйл ажиллагаанд, 4.5-12.7 (11.3%-31.8%) цагийг бичиг баримтын ажилд, 5.7-8.1 (14.3%-20.3%) цагийг хувийн хэрэгцээнд зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийн 10%-11%-г захиалга өгөх, 12%-35%-г орлого авах, 55%-88%-г тасгийн захиалга бэлдэх, олгох, батлах, 10%-12%-г тавиураа эм, тариагаар дүүргэхэд зарцуулж байна. (Зураг 8.)

Дүгнэлт

1. Судалгаанд нийт 42 мэргэжилтэн хамрагдсанаас ихэнх хувь (45%)-ийг 26-35 насныхан эзэлж, боловсролын зэргийн хувьд 81% нь бакалавр, 5% нь магистр, 14% нь диплом, мэргэжлийн зэргийн хувьд 5% нь тэргүүлэх зэрэгтэй байна.
2. II, III шатлалын эмнэлгүүдийн эм зүйн албаны мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг хронометражийн аргаар судлахад ажлын 5 өдөрт дунджаар 44.9 ± 3.236 цаг ажиллаж, үндсэн ажилд 12.5-20.4 (31.25%-51%) цаг, бичиг баримтын ажилд 8.2-14.2 (20.5%-35.5%) цагийг тус тус зарцуулдаг нь судалгаагаар тогтоогдлоо.
3. Эмнэлгийн эм зүйн албаны ажлын ачаалал долоо хоногийн мягмар болон пүрэв гаригуудад хамгийн их ачаалалтай ба 9.1 цаг харин даваа гаригт 8.7 цаг тус тус ажиллаж байгааг тогтоолоо. Судалгаанд хамрагдсан нийт 42 мэргэжлийн ажилчид нь долоо хоногт хамгийн багадаа 35.15 цаг, хамгийн ихдээ 51.62 цаг ажиллаж, дундаж цаг нь 45.015 ± 3.236 байгааг тогтоов.

Ном зүй

1. Эм зүйн салбарын үзүүлэлт. Улаанбаатар хот:2022, х.15;
2. Золжаргал, П Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн ажлын ачааллын судалгаа. Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар хот:2021, х.2-4;
3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд,

- Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал. Дугаар А/185, А/252. Аргачлал батлах тухай . Улаанбаатар хот:2019;
4. Контент-анализ, Википедиа:2023.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн: ЭЗУ-ы доктор, дэд профессор Б.Цэрэндолгор